

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХӨТӨЛБӨРИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

2022.12.14

Цагааннуур сум

№	Мөрийн хөтөлбөрийн заалт	Хэрэгжилт	Хувь
<b>Нэг. “Ковид-19” болон бусад халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого</b>			
1.1	“Ковид-19” болон бусад халдварт цар тахлын үед эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн бодлого төлөвлөлтийн бэлэн байдлыг хангаж хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.	“Ковид-19” цар тахлын үед ажиллах эмч мэргэжилтний судалгааг гаргасан. 2022 онд ерөнхий мэргэжлийн их эмч 1, уламжлалын их эмч 1, сувилагч 2, туслах сувилагч 1-ийг тус тус шинээр томилон ажиллуулсан. Одоогоор 23 орон тоотой ажиллаж байна.	100%
1.2	“Ковид-19” халдварт цар тахлын үед эрүүл мэндийн байгууллагуудын оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйжүүлэлтийн бодисыг урьдчилан нөөцлөх, түргэвчилсэн оношлуур болон РТ-ПСР төхөөрөмжөөр хангана.	2022 оны жилийн эцсийн байдлаар “Ковид-19” цар тахлын халдварын тохиолдол 98 бүртгэгдсэн бөгөөд бүх иргэнийг эмчилгээнд бүрэн хамруулсан. Эрүүл мэндийн төвийн хэмжээнд халдвараас сэргийлэх болон эмчилгээнд шаардагдах 2 сарын эм, тарианы нөөцтэй ажиллаж байна..	100%
1.3	Иргэд, олон нийтэд “Ковид-19” халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх, сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх ажлыг эрчимжүүлнэ.	Эрүүл мэндийн төвийн 1 их эмч, Ахлах сувилагч нар “Ковид-19” халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалтад 1 удаа хамрагдсан. Цаг уурын байдалтай холбоотой мэдээлэл, ухуулга, сурталчилгааг эмнэлгийн <a href="#">Selenge Tsagaannuur Emt</a> хаягаар тогтмол байршуулсан. Энэ оны байдлаар нийт 32 мэдээлэл оруулсан. Эмнэлгийн эмч ажилчдыг коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх үүднээс витаминжуулах аяныг 1 сар өрнүүлж, 24 ажилтныг хамруулсан.	100%
1.4	“Ковид-19” цар тахлын дэгдэлтийн үед эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийг нэн түрүүнд шийдвэрлэж, үйл ажиллагааг тасалдуулахгүй явуулах нөхцөл боломжоор хангана.	2021 онд хариу арга хэмжээ авах, эмнэлгийн бэлэн байдлыг хангах, шаардлагатай тохиолдолд нөөц нэмэгдүүлэх зорилгоор 3 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулсан.	0%
1.5	Томуу, томуу төст өвчин, улаанбурхан, улаанууд зэрэг амьсгалын замын халдварт өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг хамруулах ажлыг зохион байгуулна.	2022 оны байдлаар 10, 11 дүгээр сард сумын хэмжээнд, эрүүл мэндийн төвийн ажилчид болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, жирэмсэн, астамтай иргэд, ахмад, 2-6 настай хүүхдүүд, нийт 408 иргэнийг томуугийн	100%

		дархлаажуулалтад хамруулсан.	
1.6	“Ухаалаг цахим сургалт”-ын орчинг нэмэгдүүлэн, хичээл, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж, багш нарын мэдлэг ур чдвар, эцэг, эхчүүдийн оролцоог дээшлүүлнэ.	Дээд шатны байгууллагаас болон ЕБС-ээс явуулсан цахим сургалтуудад нийт 1045 сурагч, 74 багш хамрагдсан. Анги бүр цахим групп, чат, бүлгээрээ эцэг эхчүүддээ сургалт зохион байгуулж ажилласан. БНСУ-ын Жежү тусгай мужийн боловсролын газрын, дэмжлэг, <a href="#">Сэлэнгэ аймгийн Боловсрол, шинжлэх ухааны</a> газрын хамтын ажиллагааны хүрээнд компьютерийн иж бүрэн кабинет хүлээлгэн өгсөн нь аймгийн хэмжээнд уг кабинет бүхий 5 дахь сургууль болсон.	100%
1.7	Нийгмийн халамж, даатгал, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдах иргэдэд банк, төлбөр тооцооны цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлнэ.	Нийгмийн халамжийн үйлчилгээ Е халамж цахим системд холбогдсон. Нийгмийн даатгалын үйлчилгээг ил тод түргэн шуурхай хүргэж байна. Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн оператор болон e-mongolia болон нийгмийн даатгалын апплекейшн ашиглан иргэд болон аж ахуйн нэгж байгууллагууд гар утаснаасаа нийгмийн даатгалын лавлагаа, тодорхойлолт авах боломжтой болсон. 2022 онд “E.Mongolia” <a href="https://daatguulagch.ndaatgal.mn/">“https://daatguulagch.ndaatgal.mn/”</a> даатгуулагчид зориулсан вэб сайт болон нийгмийн даатгалын гар утасны “ndaatgal.mn” аппилкэйшн ашиглан даатгуулагчид үйлчилж байна.	100%
1.8	Онцгой нөхцөл байдлын үед гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хамгаалах тусламж дэмжлэг, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ.	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах, энэ талаарх иргэдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд сумын төвийг тойрсон хатуу хучилттай зам дагуу 3 ширхэг нөлөөллийн самбар байрлуулсан. Самбараар дамжуулан гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээллийг хүлээн авах утсыг сурталчилсан бөгөөд ингэснээр 108 дугаарын утасны талаарх иргэдийн ойлголт нэмэгдэж хүчирхийлэл үйлдэх гэж байгаа болон үйлдсэн этгээдүүдийг түргэн шуурхай илрүүлэх ажилд иргэдийн оролцоо нэмэгдээд байна. Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлж сумын хамтарсан баг сумын хэмжээнд хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой нийт 21 кейсийг шийдвэрлэж ажилласан.	100%
1.9	Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн өрх, иргэдэд үзүүлэх халамж, эрүүл мэндийн тусламж,	Зорилтот бүлгийн 357 хүнд урьдчилан сэргийлэх үзлэгийг хийж, өвчлөл илэрсэн 62 хүнийг эмнэлэгт хэвтэн	100%

	үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	эмчлүүлсэн. Асаргаа шаардлагатай 5 ахмад настан, 3 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 2 хүүхдийг байнгын асаргаанд оруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй 9 иргэнийг сэргээн засах тусламж үйлчилгээ, 45 иргэнийг өдрийн эмчилгээнд оруулсан.	
1.10	Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг орон нутгийн төсвийн боломжид үндэслэн төлөвлөн батлуулж, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, халдвар хамгааллын хэрэгслээр мэргэжлийн байгууллагуудыг хангана.	2022 онд ковидын 98 тохиолдол бүртгэгдсэн. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын дэгдэлтийн үед эмнэлгийн тусламж үйлчилгээ хэвийн тасралтгүй явагдсан. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын дэгдэлтийн үед эмнэлгийн тусламж үйлчилгээг гэрээр үзүүлж, эмчийн заавар зөвлөгөөг утсаар өгч ажилласан.	100%
1.11	Коронавируст халдвар /Ковид-19/-ын эдийн засагт үзүүлэх нөлөөг багасгах зорилгоор Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогыг орон нутагт зохион байгуулж, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж ажиллана.	Ковид-19 цар тахлын тархалт багасаж, хорио цээр тавигдсан тул жижиг дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа хэвийн явагдаж эхэлсэн. Үйл ажиллагаа явуулж буй жижиг дунд бизнес эрхлэгчдэд халдвар хамгааллын дэглэмээ баримтлан ажиллахыг зөвлөж ажилласан.	100%
<b>Хоёр.Хүний хөгжлийн бодлого</b>			
<b>2.1.Эрүүл мэнд.</b> Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх оношилгоо, эмчилгээнд “Ухаалаг цахим” технологийг нэмэгдүүлнэ.			
2.1.1	Хүн амын дунд халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоо, шинжилгээг тасралтгүй зохион байгуулна.	2022 оны жилийн эцсийн байдлаар сумын хэмжээнд Халдварт бус өвчний илрүүлэх дараах үзлэг явагдаж байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>➢ Артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт 1730 буюу 52.7%</li> <li>➢ Чихрийн шижин хэв шинж-2 эрт илрүүлгийн үзлэгт 1477 буюу 94.3%</li> <li>➢ Элэгний хорт хавдар эрт илрүүлгийн үзлэгт 867 буюу 55.2%</li> <li>➢ Урьдчилан сэргийлэх үзлэгт 814 буюу 19.4%</li> <li>➢ Умайн хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт 32 буюу 13.5%</li> <li>➢ Хөхний хорт хавдрын эрт илрүүлэгийн үзлэгт 88 буюу 54%-ийг тус тус хамруулсан байна.</li> <li>➢ 0-17 насны хүүхдийн эрт илрүүлгийн үзлэгт-1736 иргэнийг тус тус хамруулсан.</li> </ul>	100%

2.1.2	Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх “Эрүүл, идэвхтэй амьдрал”, “Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх”, “Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Хавдрын эсрэг”, “Элэг бүтэн Монгол”, “Харшлаас сэргийлэх”, “Эрүүл гэр бүл - Эрхэм баян” арга хэмжээг зохион байгуулна.	2022 оны 11 сарын байдлаар дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.Үүнд: Эрүүл идэвхтэй амьдрал, “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд”,“Хавдрын эсрэг”, “Харшлаас сэргийлэх”, “Эрүүл чийрэг эр хүн”, “Халдварт бус өвчин”, “Халдварт өвчин”, “Орчны эрүүл мэнд болон нийт 11 хөтөлбөрөөр төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангаж ажилласан. Хөтөлбөрийн хүрээнд сумын хэмжээнд 1 бүсийн хэмжээнд арга хэмжээ явуулж, сургалт, сурталчилгаа 27 удаагаар 857 хүнийг хамруулсан. Гарын авлага сургалтын материал 3256 ширхгийг хэвлэж тараасан.	100%
2.1.3	Иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд цахим технологийг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	Эрүүл мэндийн төв нь тусламж үйлчилгээг, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр цахимаар бүрэн авах боломжийг бүрдүүлж <a href="https://e-hospital.mn/">https://e-hospital.mn/</a> сайтаар үйлчлүүлэгчдийг бүртгэж байна.	100%
2.1.4	Мэргэжлийн өндөр, ур чадвартай, туршлагатай нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн ажилтныг гэрээний тусгай нөхцөлтэйгээр ажиллуулах, гадаад дотоодод туршлага судлуулах, давтан сургах арга хэмжээг үе шаттай зохион байгуулна.	2022 оны байдлаар шинээр уламжлалт эмчилгээний их эмч авч ажиллуулж байгаа бөгөөд сурах гэрээг одоогоор 1 тусгай мэргэжилтэн, 2 ажилтан хийсэн. Эмнэлгийн 3 мэргэжилтэнд 100% мэргэжил олгохоор цалинтай сургаж байна.	100%
2.1.5	Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд эрүүл мэндийн боловсрол олгож “Эрүүл хүүхэд-Эрүүл ирээдүй” эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж эрүүлжүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	“Шүд эрүүл бол бие эрүүл” мэргэжлийн шүдний эмчийн үзлэгт 2 дугаар цэцэрлэгийн 171 хүүхдийг үзлэг оношилгоонд хамрууллаа. Үзлэгээр амны хөндийн болон шүдний үзлэг оношилгоо, эрүүл шүдтэй хүүхдүүдэд шүд цоорлоос хамгаалах түрхлэг түрхэх, багш болон эцэг эхчүүдэд зөвлөгөө өгөх зэрэг үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлсэн.	100%
2.1.6	Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ.	Эмнэлгийн эмийн сан нь Монгол Эм Импекс Концерн ЭХНБ-тай гэрээ байгуулан хэвтэн эмчлүүлэгчдэд болон яаралтай тусламжид тасарсан эм тариа, эмнэлгийн хэрэгсэл, бараа материалыг татан авч ажиллаж байна. 2023 онд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн судалгааг гаргаж, аймгийн Эрүүл мэндийн газарт тендерийн захиалгыг хүргүүлсэн.	70%
2.1.7	Зарим сумын Эрүүл мэндийн төвүүдийг шүдний эмчээр хангаж, шүдний кабинеттай болгоно.	2022 онд Атартрейд ХХК, МУ-ын арслан Б.Орхонбаяр нар хамтран сумын ЭМТ-д 23.0 сая төгрөгийн өртөг бүхий шүдний кабинетын иж бүрэн тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн.	100%

2.1.8	Эмч, эмнэлгийн ажилтнуудын тогтвор суурьшилтай нөхцөлийг хангаж, мэргэжлийн ёс зүй, харилцаа хандлага, хариуцлагыг дээшлүүлнэ.	Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор Эрүүл мэндийн төвийн ажиллагсдын байрны суурь тавигдан баригдаж байгаа бөгөөд “Төрийн орон сууц” корпорацтай хамтран 2 өрөө байрыг гэрээний дагуу худалдан авч шинээр суманд ирж ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг түр суулгаж байна. Эрүүл мэндийн төвийн 1 албан хаагч дээрх сууцанд амьдарч байна.	70%
<b>2.2. Боловсрол</b> <b>Хөгжлийг түүчээлэх чадвартай монгол хүнийг хөгжүүлнэ.</b>			
2.2.1	Ерөнхий боловсролын сургуулийн “Мэргэжилт сонголт” арга хэмжээг үе шаттай зохион байгуулж, гадаад, дотоодын их, дээд, ерөнхий боловсролын сургууль болон бусад боловсролын байгууллагуудтай олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллана.	Мэргэжлийн чиг баримжаа олгох талаар 5 удаагийн сургалтыг зохион байгуулж, 5 багш, 82 сурагчийг хамруулсан. Ахлах ангийн АУБ нар ангийн сурагчиддаа “Мэргэжлийн үнэ цэнэ”, “Мэргэжил сонгохын учир”, “Мэргэжил гэж юу бэ” сэдэвт сургалт хичээл, зөвлөгөөг өгч ажилласан ба давхардсан тоогоор 172 сурагчдыг хамруулсан байна.	100%
2.2.2	“Сургалтын байгууллага-тоног төхөөрөмж” арга хэмжээ хэрэгжүүлнэ.	БНСУ-ын Жежү тусгай мужийн Боловсролын газар, Сэлэнгэ аймгийн БШУГ-ын хамтын ажиллагааны хүрээнд багш, сурагчдын мэдээллийн технологийн чадавхыг нэмэгдүүлэх зорилготойгоор мэдээлэл зүйн орчин үеийн тоног төхөөрөмж бүхий тохилог анги танхимаар хангагдсан. Уг ажлын үр дүнд сурагчдын мэдээлэл технологийн мэдлэг, чадвар нэмэгдэхийн зэрэгцээ багш нарын заах арга зүй болон ИТ мэдлэг дээшлэх ач холбогдолтой юм. Мөн уг зорилтын хүрээнд Боловсролын газраас 2 дугаар цэцэрлэгт зөөврийн болон суурин компьютер тус бүр 1 ширхэг, сумын ЗДТГ-аас АЗ өнгөт принтер олгосон. Мөн төсвийн хөрөнгөөр 2 ширхэг зөөврийн компьютер, 3 үйлдэлт принтер 2, дотор камер 4, гадна камер 2 нэмж суурилууллаа. Гал тогоо иж бүрэн тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан	100%
2.2.3	“Чадварлаг багш” арга хэмжээг зохион байгуулна.	БМДИ-ийн анхны жилийн сургалтад 2 багш цахимаар хамрагдаж амжилттай суралцсан. Мэргэжлийн бүлгийн сургалтад цахимаар 2 удаа давхардсан тоогоор 12 багш, арга зүйч хамрагдсан. БМДИ-ийн Сайжруулсан сургалтын хөтөлбөрийн болон сурлагын хоцрогдол арилгах сургалтад 6 багш 1 арга зүйч, ОУ-ын "Эко сургууль, цэцэрлэг" Мөнгөн гэрэгэ хөтөлбөрийн 3 дахь шатны	100%

		<p>сургалтад танхимаар 3 удаа нийт 15 багш /давхардсан тоогоор/ сурсан. Түүнчлэн ажлын байрандаа цэцэрлэгийн захиргаанаас болон ЗАН-ээс 11 удаа арга зүй, ёс зүй, харилцааны сургалтуудыг зохион байгууллаа. Сэлэнгэ аймгийн БШУГ-аас зохион байгуулан явуулж буй “Багш миний туршлага” сэдэвт арга зүйн сургалт 2022 оны 3,4 сард нийт 6 удаа чиглэл тус бүрээр зохион байгуулагдан явагдсан байна. Уг арга хэмжээнд нийт багш нараа бүрэн хамруулан оролцуулж багш нарын заах арга ур чадварыг дээшлүүлэн ажиллаж байна. БМДИ, Боловсролын газар, сум орон нутаг, байгууллагаас зохион байгуулсан нийт 18 удаагийн сургалтад давхардсан тоогоор 144 багш хамрагдсан. БМДИ-ийн СӨБ-ын байгууллагын удирдах ажилтны хөгжил хариуцсан арга зүйч багшийн "Тэгш хамруулан сургах боловсролын эрх зүйн орчин", "Боловсролын харилцаа-Багшийн нөлөөлөл", БМДИ-ийн багшийн "Зайн сургалтын онол арга зүй", Нийслэлийн СӨБ-ын мэргэжилтэн багшийн "СӨБ-ын баримтлах бодлого", БГ-ын мэргэжилтэн, эрхлэгч нарын хамтран зохион байгуулсан "Хөдөлмөрийн хууль-Хөдөлмөрийн гэрээ", "Мэргэжлийн зэрэг олгох хасах журам", "Хүүхэд хамгаалал", "Цэцэрлэг ЕБС-ийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх журам А\803 дугаар тушаал", "Байгууллагын хөгжлийн менежмент-Стратеги төлөвлөгөө боловсруулах арга" зэрэг сэдэвт сургалтуудад цахимаар хамрагдсан.</p>	
2.2.4	<p>Судалгаа, арга зүйн байгууллагуудтай хамтран сургууль, цэцэрлэгийн сургалтын чанарыг сайжруулна.</p>	<p>БМДИ болон Боловсролын хүрээлэн, БШУЯ-аас “Сургалтын сайжруулсан хөтөлбөр”-ийг хэрхэн хэрэгжүүлэх, сургалтын агуулгын хоцрогдолыг арилгах үүднээс Сэлэнгэ аймгийн хэмжээнд “Мэргэжлийн бүлэг” нээж СӨБ-ын багш нар болон арга зүйчид арга зүйн сургалт семинар, хэлэлцүүлэгт хамрагдаж, хоцрогдсон агуулгаар сургалтын нэгдсэн хөтөлбөр боловсруулан түүнийгээ хүүхэд бүрдээ цахим хичээл болгон багш бүр давхардсан тоогоор 42 хичээл бэлтгэж хүргэсэн. Энэ нь сургалтын чанар хүртээмжид сайнаар нөлөөлж байгаа бөгөөд энэ нь хүүхдийн хөгжлийн ахицаас харагдаж байна. Боловсролын газраас арга зүйч, багш нарт хүүхдийн ахицын үнэлгээг хийх, танхим болон танхимын бус</p>	100%

		сургалтын хөтөлбөрийг хэрхэн боловсруулах арга зүйн зөвлөгөө өгч сургалт зохион байгуулсан бөгөөд 7 багш арга зүйч эрхлэгч хамрагдаж хүүхдийн ахицын үнэлгээг гаргалаа. 2020-2021 оны хичээлийн жилд хүүхдүүдийн ерөнхий чадвар чадамжийг хяналтын хуудас, рубик үнэлгээ, чөлөөт ажиглалтын тэмдэглэл, дасгал даалгавар зэргээр түвшин тогтоосон. Хүүхдийн хөгжлийн ахицын үнэлгээ 83%-тай байна. Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулсан багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд 47 багш хамрагдсан ба 1-р түвшинд 4 багш, 2-р түвшинд 17, 3-р түвшинд 26 багш үнэлэгдсэн байна. Үнэлгээг шалгуураар задалбал суралцагчийн сурах үйл ажиллагааны үр дүнгийн ахиц-54.7%, суралцагчийн хөгжил, хамгаалал, төлөвшил-99,1%, багшийн мэргэжлийн хөгжил-91,6%, сургууль олон нийтийн үйл ажиллагаанд оруулсан хувь нэмэр-88,0% үнэлэгдсэн. Элсэлтийн ерөнхий шалгалтанд нийт 37 сурагч 7 хичээлээр орсон ба дундаж 481,1% үнэлэгдсэн байна. Энэ нь өмнөх оноос 3.6%-аар өссөн үзүүлэлттэй байна.	
2.2.5	Тусгай хэрэгцээт хүүхдийг сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.	СӨБ-д хамрагдаж байгаа тусгай хэрэгцээт хүүхдийн суралцах үйлийн онцлогт тохируулан дасгал даалгавар, ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна. СӨБ-д 6 тусгай хэрэгцээт хүүхэд суралцаж байгаа бөгөөд эдгээр хүүхдүүдэд зориулан 6 бүлгийн ариун цэврийн өрөөний суултуурын хажуу хаалтад 24 ширхэг бариул суурилуулсан.	100%
2.2.6	Ерөнхий боловсролын лаборатори 4 дүгээр, Мандал сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль болон Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулиудын хичээлийн байрны өргөтгөл, зарим шаардлагатай сургуулийн спорт заал, дотуур байрыг шинээр барих, сургууль, цэцэрлэгүүдийн их засварын ажлыг ээлж дараатай шийдвэрлэнэ.	Улсын төсвийн хөрөнгөөр баригдах 320 хүүхдийн суудалтай сургуулийн өргөтгөлийн барилгын ажилд “Асуд констракшн ХХК” шалгарч барилгын шугамын ажил хийгдсэн. 2023 оны Улсын төсөвт 1 тэрбум 930 сая төгрөг батлагдсан.	100%
<b>2.3.Биеийн тамир, спорт</b>			
Бүх нийтийн биеийн тамирыг дэмжих замаар иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, дадал хэвшлийг бий болгоно.			
2.3.1	“Спортлог Сэлэнгэчүүд” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилга, Биеийн тамир, Спортын улсын хорооноос зохион байгуулж буй	100%

		“Илүүдэл жингүй –Эртэч Монгол” аян зарлагдаж Сумын хэмжээнд давхардсан тоогоор 1756 иргэд хамрагдаж, хамрагдсан иргэдийг 06-70 насны иргэд оролцлоо. Өглөө бүр иргэд алхалт хийж гүйж, сурагчид дугуй унах, ахмадууд иог, дасгал, шугам бүжгээр хичээллэж, Ерөнхий боловсролын сургуулийн багш ажилчид, 1200 гаруй сурагчид үдийн завсарлагаанаар дасгал хөдөлгөөн хийж хэвшлээ.	
2.3.2	“Эрүүл иргэний төлөө хамтдаа” хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд өрнүүлж, үр дүнг тооцно.	“Илүүдэл жингүй–Эртэч Сэлэнгэчүүд” аяныг сумын хэмжээнд өрнүүлж төрийн болон төрийн бус байгууллага , аж ахуйн нэгжүүд, иргэдийг 07:30-08:30 минут хооронд өглөөний дасгалд хамруулж, ахмадуудын дунд “Эрүүл бие-Эрч хүч” уриан дор *Алхангаа ярилцацгаая* явган аялалыг зохион байгуулж нийт 70 гаруй ахмадууд хамруулсан. Мөн уг аяны хүрээнд ахмадуудын дунд “Софт волейбол”-ын тэмцээн, сумын иргэдийн дунд “Үүргэвчтэй аялал” явган аялал, ерөнхий боловсролын сургуулийн 9-12 дугаар ангийн сурагчдын дунд волейболын тэмцээн зохион байгуулсан.	100%
2.3.3	Аймгийн Засаг даргын нэрэмжит төрийн албан хаагчдын дунд спортын олон төрөлт тэмцээнийг жил бүр зохион байгуулна.	Сэлэнгэ бүсийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын нөхөрсөг тэмцээнийг 6 төрлөөр Зүүнбүрэн суманд зохион байгуулж, багийн дүнгээр сумын ЗДТГ-ын албан хаагчид тэргүүн байр эзэлсэн.	100%
2.3.4	Биеийн тамир, спортын салбарын хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, чадавхижуулах, мерит зарчмын дагуу шат шатны байгууллагуудад шатлан ажиллуулах бодлого хэрэгжүүлнэ.	Спортын салбар нь 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.	70%
2.3.5	Үндэсний спортын төрлөөр хичээллэгсэд болон сонирхогчдын тоог нэмэгдүүлж, хүүхэд, залуучуудад өвлүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.	Үндэсний бөхийн болон чөлөөт бөхийн дугуйланд нийт 20 гаруй хүүхэд хамрагдаж байна.	100%
2.3.6	Тамирчдын ур чадварыг ахиулж, улс, тив, дэлхийд өрсөлдөхүйц тамирчдыг бэлтгэнэ.	“Илүүдэл жингүй–Эртэч Монгол” аяны хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 21-ний өдөр нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор “Цагааннуур Марафон-2022” тэмцээнийг 12-13 нас, 14-15 нас, 16-17 нас, 18-35 насны ангиллаар зохион явууллаа. Тэмцээнд нийт 200 гаруй хүүхэд болон насанд хүрэгчид оролцлоо. Шалгарсан тамирчид Сэлэнгэ аймгийн марафон гүйлтийн тэмцээнд орохоор бэлтгэл байдлаа	100%



		хангасаар байна.	
2.3.7	Иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх орчин, нөхцөлийг сайжруулна.	Спорт цогцолборын барилгын засварын ажлыг аймгийн ОНХСангийн хөрөнгө 297,5 сая төгрөгөөр “Дээдсийн жигүүр ХХК” шалгаран ажлыг 100 хувь хийж гүйцэтгэн хүлээлгэж өгсөн.	100%
<b>2.4. Соёл, урлаг</b>			
Хүний хөгжилд соёл урлагийн үр нөлөөг нэмэгдүүлж, соёл уламжлалаа дээдэлдэг иргэн төлөвшүүлнэ.			
2.4.1	Хүүхэд, залуучууд, уран бүтээлчдийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэн, улсын болон олон улсын чанартай уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлнэ.	Сумын ардын авьяастан М.Атар нь Сэлэнгэ аймгийн Ерөө суманд зохиогдсон ая зохиогч Б.Ганболдын дууг хэн сайн дуулах вэ тэмцээнд амжилттай оролцон тусгай байр эзэлсэн. Нэрт яруу найрагч Г.Сэр-Одын нэрэмжит "ДУНГИЙН ЭГШИГ" өсвөрийн яруу найрагчдын 32 дахь жилийн наадамд 8-9-р анги:төрөлд 9в ангийн сурагч Ж.Төвсайхан, 6-7-р анги: төрөлд 7б-р ангийн сурагч С.Отгонзаяа нар шалгаран оролцлоо. Тус уралдаанд 9в ангийн сурагч Ж.Төвсайхан ТЭРГҮҮН байранд шалгарч амжилттай оролцлоо.	100%
2.4.2	“Бид Сэлэнгийн үр сад”, “Эв модны наадам”, “Монгол өв соёл-Монголын дархлаа”, “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл” зэрэг томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулан өв соёлыг түгээн дэлгэрүүлнэ.	Монгол Хөөмий, Уртын дууг нутагшуулах хөгжүүлэх анхан шатны сургалтад Ардын авьяастан М.Атар, Н.Отгонбаяр нар амжилттай суралцан анхан шатны мэдлэг эзэмшсэн.	70%
2.4.3	“Сэлэнгэ соёл” үзэсгэлэн худалдааг зохион байгуулна.	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор хүүхэд, иргэд болон бүсгүйчүүдийн дунд “Полимор” урлал болон “Нэхмэл гутал”-ын гар урлалын сургалтыг, сургагч багштай нартай хамтран зохион явуулсан. Бэлэг дурсгалын зүйлс болон шүрэн эдлэлийн урлалыг эзэмшигч 6 иргэний бүтээлийн үзэсгэлэнг 2 удаа зохион байгуулсан. Мөн иргэдийн дунд “Соёлын бүтээлч үйлдвэрлэл” уралдаан зарлаж нийт 6 иргэний бүтээлийг нийтэд үзүүлэн оролцогчдыг шагнаж урамшуулсан.	100%
2.4.4	Монгол өв соёлоо ур чадварын өндөр түвшинд өвлөсөн билиг авьяастнуудыг алдаршуулна.	Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдаа сурталчлан, алдаршуулах зорилготой Бие биелгээ, Морин хуурын татлага өвийн өвлөн уламжлагч 4 дахь үеийн бийч МУТААвьяастан Ч.Шинэбилэг, гар урлал дархан өвлөн уламжлагч Аймгийн бүтээлч ардын авьяастан Г.Гэндэнсүрэн, Доржсүрэн, Өвлөн уламжлагч	100%

		МУСТАжилтан Ч.Алтанхуяг, МУТУС Х.Нацаг, Аймгийн бүтээлч ардын авьяастан Д.Соном, МУТАА Р.Энхжаргал, МУСТАжилтан Б.Жаргалсайхан нарын 8 авьяастны танилцуулга фото зургийн мэдээллийг “Цагааннуур Соёлын төв” цахим хуудсанд байршуулан нийтэд сурталчлан танилцуулсан.	
2.4.5	“Сэлэнгэ сайхан нутаг”-ийн байгалийн өвийг баримтжуулж, хамгаалан түгээн дэлгэрүүлнэ.	Сумын бүртгэл мэдээллийн санд нийтдээ 207 түүх соёлын үл хөдлөх дурсгал бүртгэлтэй байдаг. 2022 онд “Миний нутгийн түүх” цуврал танилцуулгыг 6 удаа Цагааннуур Сум Соёлын Төв фэйсбүүк цахим хаягаар сурталчиллаа.	100%
2.4.6	“Цахим номын сангийн сан хөмрөгийн үйлчилгээ”-ний хэрэглээг нэмэгдүүлнэ.	Цахим номын сангийн сан хөмрөгт нийт 42 буюу сиди бичлэг 26ш, уран зохиол 16 ш байдаг. Иргэд олон нийтэд “Монголын нууц товчоо”-г сурталчлан таниулах зорилгоор “Нууц товчооноос суралцъя” цуврал мэдээлэл, Х.Дуламсүрэнгийн “Нэгдүгээр сарын бороо”, “Сонголт”, “Нартай буцсан амьдрал”, “Зүрхэнд нуугдсан хайр” зэрэг зохиолуудыг <a href="#">@Цагааннуур Сум Соёлын Төв</a> цахим хуудсанд цувралаар байршуулан 879 уншигч хамрагдав.	100%
2.4.7	Аймгийн Музей болон орон нутгийн судлах танхимд эх орныхоо түүх соёлыг таниулах зорилгоор хүүхдийн нас сэтгэхүйд тохирсон үзмэрүүдээр баяжруулж, виртуал хэлбэрээр үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	Өөрийн орон нутгийн ТСДЗүйлсийн фото альбомыг хийж нүүдлийн үзэсгэлэнд ашиглаж байна. Байгалийн чулуун цуглуулгаар танхимын үзмэр нэмэн баяжуулсан.	50%
<b>2.5. Хүүхэд, залуучууд, гэр бүлийн бодлого:</b>			
<b>Гэр бүл, хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжиж, иргэн бүрт хүрсэн шуурхай үйлчилгээг бий болгоно.</b>			
2.5.1	Гэр бүл, хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд зохион байгуулж, “Хүчирхийлэлгүй аймаг” болох бодлогыг хэрэгжүүлнэ.	Гэмт хэрэг зөрчилд өртөж болзошгүй хүүхдүүдийн 37 эцэг эх, асран хамгаалагчтай нийгмийн ажилтан уулзаж, ярилцлага хийж, ганцаарчилсан зөвлөгөө өгч ажилласан. Сумын хамтарсан баг архины хамааралтай, хүчирхийлэлтэй нийт 19 гэр бүлд очиж үйлчилгээ үзүүлсэн. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах, энэ талаарх иргэдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд сумын төвийг тойрсон хатуу хучилттай зам дагуу 3 ширхэг нөлөөллийн самбар байрлуулсан. Самбараар дамжуулан гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээллийг хүлээн авах утсыг сурталчилсан бөгөөд ингэснээр 108 дугаарын утасны	100%

		талаарх иргэдийн ойлголт нэмэгдэж хүчирхийлэл үйлдэх гэж байгаа болон үйлдсэн этгээдүүдийг түргэн шуурхай илрүүлэх ажилд иргэдийн оролцоо нэмэгдээд байна.	
2.5.2	Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдлэг, мэдээллийг олгох ажлыг зохион байгуулна.	Харилцаа хандлага, төлөвшил, гэр бүл төлөвлөлт сэдвээр 2022.12.02 ний өдөр сургуулийн 9-12-р ангийн 380 сурагчид сургалт зохион байгуулсан.	100%
2.5.3	Хүүхдийг болзошгүй эрсдэл, осол гэмтэл, гэмт хэрэг, цахим орчны нөлөөллөөс урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	Хүүхдийг гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлж сургуулийн багш ажиллагсдад “Хүүхэд хамгаалал-Хамтарсан баг” сэдэвт сургалт, 6-11 дүгээр ангийн сурагчдад “Үе тэнгийн дээрэлхэлд, гадуурхалт” сургалт, 6-12 дугаар ангийн хөвгүүдэд “Хорт зуршил” сургалтуудыг явуулж давхардсан тоогоор 812 эцэг эх, асран хамгаалагч, сурагчдыг хамруулсан. Мөн гэмт хэрэг зөрчилд өртөж болзошгүй хүүхдүүдийн 37 эцэг эх, асран хамгаалагчтай нийгмийн ажилтан уулзаж, ярилцлага хийж, ганцаарчилсан зөвлөгөө өгч ажилласан . Сумын хамтарсан баг архины хамааралтай айл өрх, хүчирхийлэлтэй айл өрх нийт 19 гэр бүлд очиж үйлчилгээ үзүүлсэн. СӨБ-ийн багш нараар дамжуулан “Гар утас тоглоом биш” гарын авлагыг 5 удаагийн үйл ажиллагаагаар 970 эцэг эх, асран хамгаалагчдад, “Дэлгэцийн донтолтоос урьдчилан сэргийлэх арга аргачлалыг түгээн дэлгэрүүлэх” сургалт нөлөөллийн ажил, “Цахим хэрэгсэлд донтох, донтолтын хор нөлөө” сэдвээр сургалт, мэтгэлцээн, “Дэлгэцийн донтолт ба гэр бүлийн анхаарал “ сэдвийн хүрээнд багш эцэг эхийн хамтарсан 2 баг хүүхдүүдэд жүжигчилсэн тоглолт, “Дэлгэцтэй биш, дэлгэсэн номтой нөхөрлөө” цуврал сургалт, “Гар утас хүүхэд аргадах тоглоом биш” сэдэвт сургалт, “Дэлгэцийн донтолтоос сэргийлж эрүүл мэндээ хамгаалцгаая” аяны хүрээнд “Спортлог гэр” бүл өдөрлөг зэргийг зохион байгууллаа. сургалтуудад давхардсан тоогоор 1100 эцэг эх, асран хамгаалагчид, сурагчид, сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг хамруулсан	100%
2.5.4	Хүүхдийн хүмүүжил төлөвшлийн асуудалд онцгой анхаарч, гэр бүлийн гишүүн бүрт зориулсан нөлөөллийн ажлыг зохион байгуулж, эцэг, эхийн	Хүүхдийг гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлж сургуулийн багш ажиллагсдад “Хүүхэд хамгаалал-Хамтарсан баг” сэдэвт сургалт, 6-11 дүгээр ангийн	100%

	үүрэг хариуцлагыг нэмэгдүүлнэ.	сурагчдад “Үе тэнгийн дээрэлхэлд, гадуурхалт” сургалт, 6-12 дугаар ангийн хөвгүүдэд “Хорт зуршил” сургалтуудыг явуулж давхардсан тоогоор 812 эцэг эх, асран хамгаалагч, сурагчдыг хамруулсан. Мөн гэмт хэрэг зөрчилд өртөж болзошгүй хүүхдүүдийн 37 эцэг эх, асран хамгаалагчтай нийгмийн ажилтан уулзаж, ярилцлага хийж, ганцаарчилсан зөвлөгөө өгч ажилласан .	
2.5.5	Залуучуудын хөгжих, тэдний эрх ашгийг хамгаалахад чиглэсэн клуб, холбоодын үйл ажиллагааг дэмжиж, хөдөөгийн залууст нөлөөллийн ажлыг хэрэгжүүлнэ.	Монголын Залуучуудын өдрийг тохиолдуулан "Хүртээмжит нийгэм-залуусын оролцоо-хөдөлмөр эрхлэлт" залуучуудын хөгжлийн сарын аяны хүрээнд "Орон нутгийн залуусаа сонсьё" хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлгээр төрөөс залуучууд руу чиглэсэн бодлого чиглэл, сум орон нутагт хийгдэж буй хөрөнгө оруулалтын талаар товч мэдээллийг залуучуудад өгсөн. Мөн Хууль, эрхзүй хариуцсан мэргэжилтэн "Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн танилцуулга, түүнтэй уялдан орон нутгийн зүгээс залуучуудыг дэмжих чиглэлээр баримталж буй бодлого, хийгдэж буй ажил, хөтөлбөрийн талаар, Эрүүл мэндийн төвийн Нийгмийн эрүүл мэндийн ажилтан залуучуудын эрүүл мэндийг хамгаалах, элдэв өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаар, Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн талаар статистик тоон мэдээлэл, хөдөлмөр эрхлэгч залуучуудыг дэмжих төсөл хөтөлбөрийн танилцуулга мэдээллийг хүргэлээ. Чуулганы эцэст залуучуудын хөгжилд тулгамдаж буй асуудал - нээлттэй санал асуулга, хэлэлцүүлгийг явуулж, залуучуудаас гарсан санал хүсэлтийг хүлээн авлаа.	70%
2.5.6	Аж ахуйн нэгж, албан байгууллагуудын нийгмийн хариуцлагын хүрээнд залуучуудын амьдрах орчин, боловсрол, гэр бүлд оруулах дэмжлэгийг нэмэгдүүлнэ.	Шинэ залуу төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор Эрүүл мэндийн төвийн ажиллагсдын байрны суурь тавигдан баригдаж байгаа бөгөөд “Төрийн орон сууц” корпорацтай хамтран 2 өрөө байрыг гэрээний дагуу худалдан авч шинээр суманд ирж ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг түр суулгаж байна. Шинэбадрах ХХК нийгмийн хариуцлагынхаа хүрээнд хувийн орон сууц барих, ажлын байр бий болгох сумын ЖДҮ эрхлэгч 3 иргэнд цэвэр банз 15*15 харьцаатай палк нийт 374.5м3 мод, модон материалыг хөнгөлөлтэй үнээр	100%

		олгож дэмжлэг үзүүлж хамтран ажилласан.	
2.5.7	Жендерийн эрх тэгш байдлыг эрхэмлэсэн соёлыг төлөвшүүлэх ажлыг бүх шатны байгууллагуудад хэрэгжүүлж, хүчирхийллээс урьдчилан сэргийлнэ.	Сумын төрийн байгууллагуудын ажилтнуудын судалгааг гаргасан. Эрүүл мэнд, Боловсролын байгууллагууд ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалан нэг хүйсийн ажилтнууд давамгайлах хандлагатай. ЗДТГ-т хүйсийн харьцаа тэнцвэртэй байна. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн баярын “Хандлагаа өөрчилж, хамтдаа хөгжье” эмэгтэйчүүдийн чуулга уулзалт, “Бүсгүйчүүд” уралдаант тэмцээн зохион байгуулсан. Уг арга хэмжээний хүрээнд Лектор Н.Алтанцоож “Харилцаа” сэдэвт сэтгэл зүйн сургалт, “Охидын дуу хоолой”, “Эмэгтэйчүүдэд тулгамдаж байгаа асуудал – шийдэл” хэлэлцүүлэг боллоо.	100%
<b>2.6.Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, даатгал</b>			
Иргэдийг аж ахуй эрхлэх ур чадварыг нь хөгжүүлж дэмжлэг үзүүлэн ажилтай, орлоготой болгоно.			
2.6.1	Иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийн хүртээмжтэй бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	2022 оны жилийн эцсийн байдлаар 88 шинэ ажлын байр бий болсон. Ажил хайгч болон ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө, мэдээллээр хангах үйлчилгээнд 20 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн. Ажлын байрны харилцаа, сэтгэл зүйн сургалтад зорилтод бүлгийн 35 иргэнийг бүрэн хамруулан зохион байгуулж иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлж ажиллаж байна.	100%
2.6.2	Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санг баяжуулж, ажилгүй иргэдийн тоог бууруулна.	Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санд нийт 152 иргэнийг бүртгэсэн. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системийн LMIS программд идэвхтэй ажил хайгчаар 130 иргэн, ажил олгогч 45 ААНБайгууллага, шинэ ажлын байранд 88 иргэн зуучилсан.	100%
2.6.3	Ахмад настны хөгжил, хамгааллын үйл ажиллагааг тогтмолжуулан, хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлнэ.	Ахмадын ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрийн хүрээнд: 1 ахмад настанд “Төмөр хийц” төслөөр 5 сая төгрөгийг 24 сарын хугацаатай олгосон. Уг төслөөрөө Сэлэнгэ аймагт болсон “Хөдөлмөрийн бүтээмж” үзэсгэлэн худалдаанд амжилттай оролцож 800.0 мянган төгрөгийн орлого олсон. Мөн ахмад настанд олгох дэмжлэг тусламжид 22 иргэнд 2200.0 мянган төгрөг, алдар цолтон ахмад настанд олгох хөнгөлөлтөд 7 иргэнд 1260.0 мянган төгрөг,хүндэт донорт олгох хөнгөлөлтөд 1 иргэнд 400.0 мянган төгрөг, байгууллагын харъяалалгүй ахмад настанд	100%

		олгох тэтгэмжид 10 иргэнд 100.0 мянган төгрөг, насны хишиг тэтгэмжид 170-аас доошгүй иргэнд 13450.0 мянган төгрөг тус тус олгосон байна. Нийт 211 ахмад настанд 22410.0 мянган төгрөг олгосон.	
2.6.4	Албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа иргэд болон малчдын нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	Сайн дурын даатгалд шинээр малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч 43 иргэн даатгуулсан. Үүнээс малчин 27, 3 хүртэлх насны хүүхдээ асарч буй малчин эх 4, хувиараа хөдөлмөр эрхлэгч 12 иргэн хамруулсан.	100%
2.6.5	Сайн дурын даатгалд хамрагдагсдын тоог нэмэгдүүлнэ.	Жилийн эцсийн байдлаар шинээр 94 иргэн сайн дурын даатгалд хамрагдсан.	100%
2.6.6	Иргэн бүрийг эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлтөөр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамруулах ажлыг зохион байгуулна.	605 иргэнд хөнгөлөлттэй эмийн жороор үйлчилсэн. Жилийн эцсийн байдлаар 1733 иргэнд 48,546,334 төгрөгийн хөнгөлөлтэй эмийн жороор үйлчилж, эрүүл мэндийн даатгалд сайн дурын даатгалд 460 иргэнийг хамруулсан.	100%
2.6.7	Тусгай хэрэгцээт иргэдийг хөгжүүлж, оролцоог ханган, ээлтэй орчин, хөдөлмөрлөх нөхцөл, боломжийг сайжруулна.	2022 оны жилийн эцсийн байдлаар Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт тусламжид 41 иргэнд 6943.6 мянган төгрөг олгосон байна. ОНОТХҮйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ гэрээрээ асардаг 1 иргэн “Боломж” оёдлын төслөөр 2 сая төгрөг олгосон. Ингэснээр хүүхдээ асрахын зэрэгцээ өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломж бүрдсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний төсөл хөтөлбөрт 1 иргэн хамрагдаж, Түүхий эд”-ээр төслөөр 8 сая төгрөгийг 50 хувийг эргэн төлөх нөхцөлтэйгөөр олгосон.	100%
<b>Гурав. Эдийн засгийн бодлого</b>			
<b>3.1.Хөдөө аж ахуйн бодлого</b>			
<b><i>Байгальд ээлжтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон цогц, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлж, эрүүл аюулгүй хүнсний хангамжийг сайжруулна.</i></b>			
3.1.1	Атрын 4-р аяныг хэрэгжүүлж, газар тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	2022 онд улаанбуудай 21576 га талбайгаас 31407,4 тонн хураан авч га-н дундаж 15,2 цн байна. Овьёос 470 га талбайгаас 351,3 тонн, тосны ургамал 6939 га талбайгаас 3357,3 тонн ургац хураан авсан байна. Төмс 112,52 га талбайгаас 1692,2 тонн, хүнсний ногоо 78,814 га талбайгаас 836 тонн ургац хураан авсан байна.	100%
3.1.2	Газар тариалангийн үйлдвэрлэлд орчин үеийн	2022 онд ХАА- яамнаас хүнсний ногооны хөнгөлөлттэй үрийг	70%

	дэвшилтэд техник, технологийг нэвтрүүлж, тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалан ойн зурвас, хашаажуулах төслийг хэрэгжүүлж, эрдэм шинжилгээний байгууллагууд, төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор ирээдүйтэй болон нутагшсан үрийн хангамжийг нэмэгдүүлнэ.	45 иргэн өгсөн. Үүнд шар лууван 2кг, шар манжин 0,5 кг, хүрэн манжин 2 кг, саримс 10 кг, урт сонгино 0,5кг, байцаа 15000 ширхэг, төл сонгино 150 кг, төмс 1000 кг тус тус хөнгөлөлттэй үнээр олгосон байна.	
3.1.3	Усалгаатай тариаланг хөгжүүлэх, мэргэжлийн байгууллагуудтай хамтран услах боломжтой талбайн судалгааг хийж, усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.	2 аж ахуйн нэгж байгууллага нийт 2458 га талбайг усалгаажуулах хүчин чадал бүхий усалалтын системийг ашиглаж байна. 2022 онд усалгаатай талбайн хэмжээ нэмэгдээгүй.	70%
3.1.4	Хүлэмжийн болон зоорины аж ахуй эрхлэлтийг дэмжиж, шинэ ургацын ногооны хангамжийг нэмэгдүүлнэ.	Хүлэмжийн болон зоорины аж ахуйг дэмжих зорилгоор 2022 онд 3 өрхөд ХХААЯ-ны хөнгөлөлттэй нөхцөлөөр 8х4 хэмжээтэй зуны хүлэмж олгосон. Мөн энэ онд Аймгийн хөрөнгө оруулалтаар суманд 1 зуны хүлэмж олгосон.	100%
3.1.5	"Жимс жимсгэнэ" хөтөлбөрийг хэрэгжүүлэн, тариалах талбайн хэмжээ, нэр төрлийг олшруулж, боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	2022 онд Цагааннуур сумын 1 иргэний Далтад байрлалтай жимс, жимсгэний зориулалттай 10 га талбайд шинээр лийр, виноград, алим, интоорын суулгацууд тариалсан.	100%
3.1.6	Тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйн суурин, хагас суурин мал аж ахуйг эрхлэн бэлчээрийн мал аж ахуйгаас татгалзаж "Сэлэнгэ мах", "Сэлэнгэ сүү", "Нарийн нарийвтар ноост хонь" төслийг хэрэгжүүлнэ.	Сумын ИТХ-д "Газар тариалангийн бүс нутагт МАА эрхлэгчдэд батламж олгох журам"-ын төслийн эхний хэлэлцүүлгийг хийж, 2 дугаар хэлэлцүүлэгт бэлтгэсэн. Газар тариалангийн бүсэд үржүүлж буй мал сүрэгт үзлэг ангилалт хийх, ашиг шимийн үзүүлэлтийг тодорхойлох баталгаажуулах, цөм сүрэг бүрдүүлэх ажлын хүрээнд эрчимжсэн, төрөлжсөн мал аж ахуй эрхэлж буй 17 малчин өрх, 1 ААН-ийг цөм сүрэг бүхий малчин өрхийн батламж олгохоор аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт уламжилсан.	100%
3.1.7	Сэлгээн дэх таримлын төрөл зүйлийг нэмэгдүүлэх замаар тариаланд ашиглагдах боломжтой атар болон атаршсан газрыг эргэлтэнд оруулан тэжээлийн ургамал тариалалтыг нэмэгдүүлж, баяжуулсан тэжээлийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	2022 онд Баяндулаан-Уул ХХК 814 га талбай, Монгол ногоо ХХК 2601 г талбай, Шаргал тариа ХХК 864 га талбай, Сэлэнгэ хүнс ХХК 1424 га талбай, Виго буудай ХХК 439 га талбай, Сэлэнгэ тос ХХК 1627 га талбайд тус тус тэжээлийн ургамал тариалсан байна.	100%
3.1.8	Мал сүргийг гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын боломжийг нээнэ.	2022 оны 1, 2 дугаар улиралд суманд гарсан малын гоц халдарт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх түүнтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд 28 хоногийн 24 цагийн 3 постыг ажиллуулсан. Шүлхий өвчний вакцинд хавар, намар 2 удаагийн	70%

		тарилгаар үхэр 52105 толгой, гахай 2236 толгой, хонь 23203 толгой, ямаа 19113 толгойг хамруулсан. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад тугал 4400 толгой, хурга 23800 толгой, ишиг 16200 толгой охин төл хамруулсан.	
<b>3.2. Байгаль орчин:</b>			
<b>Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.</b>			
3.2.1	Ус, хөрсийг хамгаалж, цөлжилт, бэлчээрийн доройтлоос сэргийлэн ойн зурвасыг нэмэгдүүлнэ.	Ойн мэргэжлийн байгууллага болох “Шинэбадрах” ХХК 2021 онд мод бэлтгэсэн талбай Гүн шүрэн гэх газар 20 га талбайд, “Бүтээлийн нуур” ХХК 2021 онд мод бэлтгэсэн талбай болох Сангалтай гэх газар 20 га талбайд Ойн мэргэжлийн байгууллага болох “Ойн хүрэм” ХХК-тай гэрээ байгуулан 05 дугаар сарын 06-наас 11-ний хооронд 88000 ширхэг шинэс модны 2 настай тарьцаар ойжуулалт хийсэн. Нийтийн эдэлбэр газарт шинээр 6 ширхэг бичил цэцэрлэг 3 га-д ногоон байгууламж байгуулсан. Үүнд нарс 258 ширхэг, гоёлын мод 360 ширхэг, иргэд гоёлын мод-21 ширхэг, жимсний мод-69 ширхгийг, ААНБайгууллага гоёлын мод-82 ширхэг, жимсний мод-184 ширхгийг тус тус тарьсан байна. Сумын хэмжээнд нийт шилмүүст мод-258 ширхэг, гоёлын мод-381 ширхэг, жимсний мод-253 буюу нийт 892 ширхгийг тарьсан байна.	100%
3.2.2	Ойн хөнөөлт хортон шавжийн олшрол, тархалтын судалгаанд тулгуурлан устгах ажлыг зохион байгуулна.	2022 онд сумын Шүрэнгийн адаг, Мойлт нуга, Баян нуга, Эрээн хайлааст, Цог өндөр, Дээд доод хоолой зэрэг газар нутагт моносны бүгэг нийтдээ 1000 га талбайд химийн аргаар химийн бодис каратег нэг га талбайд 0.24 мл орохоор тооцоолон. Хөнөөлт шавжийн үхэл буюу техникийн үр дүн 91.7 хувьтай байна.	100%
3.2.3	Ойгоос мод бэлтгэх хуваарь мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээний олголтыг цахим хэлбэрт шилжүүлнэ.	Хэрэгжээгүй	0%



3.2.4	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг эрчимжүүлж, хилийн шороон зурвасыг сэргээх ажлыг зохион байгуулна.	Гал түймрийн хуурайшилттай үед багийн Засаг даргатай хамтран 1, 2, 3-р багийн 508 малчин өрхийн 1096 иргэнд, 46 ААН-д Ойн тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, түлээний мод бэлтгэхэд анхаарах зүйлс, Ойн дагалт баялаг, жимс жимсгэний тухай, Ан амьтны тухай хуулиар гарын авлага бэлтгэн тарааж ой хээрийн болон объектын гал түймрээс урьдчилан сэргийлэх, үнс нурмаа ил задгай асгахгүй байх, насанд хүрээгүй хүүхдийг түймрийн аюултай үед чүдэнз, асаагууртай явуулахгүй байхыг анхааруулж, гарын үсгээр баталгаажуулан авсан.	70%
3.2.5	Түүхэн болон байгаль экологи, эдийн засгийн хувьд ач холбогдолтой газар нутгийг хамгаалалтад авах ажлыг зохион байгуулна.	Усны нөөцийг бохирдож, хомстохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17.1.1, Усны тухай хуулийн 13.1.3, 13.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн усны сан бүхий газар, түүний хамгаалалтын бүс, орчмын газрын хог хаягдлыг бүрэн цэвэрлэх ажлын хүрээнд 09 дүгээр сарын 07-08-ны хооронд зохион байгуулсан. Үүнд нийгмийн халамжийн зорилтод бүлгийн иргэд Цагаан худаг, Лхамхай овооны булаг шандыг хогийг цэвэрлэж усны бохирдлыг бууруулж хамтран ажилласан. Мөн Сэлэнгэ голын ой сав, Бүдүүний гүүрний хяналтын цэгийн орчим гол бохирдуулах, хог хаях зэрэг зүй зохисгүй байдалд хяналт тавьж, хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх, хог хаяхгүй байх талаар иргэд аялагчдад мэдээлэл сурталчилгаа явуулах, нөлөөллийн ажлыг орон нутагтаа байнга зохион байгуулан ажиллаж байна. Мөн сумын ЗДТГ-ын ажилтан албан хаагч, байгаль хамгаалагчид 3 км орчим хогийг түүж цэвэрлэсэн.	100%
3.2.6	Хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах үйлдвэр байгуулж аюултай хог хаягдлыг түр хадгалах, устгах байгууламжийн тоог нэмэгдүүлнэ.	Хогийн цэгт иргэд хогоо асгах зам талбай гаргуулах ажилд Бүтээлийн нуур ХХК-тай 2021 оны 01-р сараас эхлэн гэрээ байгуулан дотор талд нь 3 удаа зам талбай гаргах явцад хяналт тавин ажиллалаа. Мөн гаргасан зам талбайд иргэд хогоо эмх цэгцгүй буулгахаас сэргийлж байгаль хамгаалагчид багийн Засаг дарга нартай хамтран 2-р сард ээлж гарган иргэдийн хог асгалтанд нь хяналт тавин шахуулж асгуулж ажилласан. Мөн 6-р сард Монгол ЛЗ зам гүүр ХХК-тай хамтран хогийн цэгийн гадна асгасан хог хаягдлыг түрж цэвэрлэхэд хяналт тавин ажиллалаа.	70%

### 3.3. Аялал жуулчлал:

**Аялал жуулчлалын салбарын тогтвортой хөгжлийг хангаж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн жуулчдын ая тухтай амрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.**

3.3.1	Байгаль экологийн онцлог, түүх соёлын биет ба биет бус өв соёлыг хадгалсан НИТАЖ/нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал/-ыг хөгжүүлнэ.	Сумын 1 багийн байгаль хамгаалагч И.Наранбаатар “Их говийн нүүдэл” ТББайгууллагын архилогич, судлаач, доктор профессор н.Ганбат, Боловсролын яамны судлаач н.Отгонбаяр, Шинжээч н.Хишгээ, 1-р багийн Засаг дарга Д.Сонсонбаярлах, Соёлын төвийн орон нутгийн музейн мэргэжилтэн С.Халиунаа нартай хамтран сумын хийд, хэрэгсүүр, булш, туурийн судалгаа хийж, тоолж ажилласан. "Цагааннуур сум байгаль орчин хуудас" болон "Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын байгаль орчны мэдээлэл түгээх групп"-ээр дамжуулан Тийрэг 3-р багт байрлах Буган чулуун хөшөө, Нүхтийн агуйн талаар мэдээлэл бэлтгэн 397 хүнд хүргэсэн байна.	70%
-------	---	--	-----

### 3.4. Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ:

**Худалдаа үйлчилгээний газруудыг орчин үеийн эрүүл ахуй, стандартын шаардлага хангуулж, үйлчилгээний чанар, харилцааны соёл дээшлүүлэх, аймаг, сум, багийн түвшинд ахуйн үйлчилгээг хөгжүүлж, нэр төрөл, чанар хүртээмжийг дээшлүүлж, хүний нөөцийг чадавхжуулан үйлдвэрлэл үйлчилгээний төвүүдийг бий болгоно.**

3.4.1	Сум бүрт нэг үйлдвэр үйлчилгээ” арга хэмжээг төр, хувийн хэвшлийн хамтарсан хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлнэ.	2022 онд шинээр “Баялаг ундраа” хэрчсэн гурилын цех, “Очир” талх, хэрчсэн гурилын цехүүд ашиглалтад орсон. Холбогдох бичиг баримтын бүрдлийг хянан зөвшөөрлийг өгсөн. Үүнд: Ажлын байрны эрүүл ахуй, стандартын шаардлагыг хагуулах, хүнсний аюулгүй байдал, дүрэм, журам холбогдох стандартыг хэрэгжүүлж зөвлөгөө, мэдээллээр ханган хяналт тавин ажилласан.	100%
3.4.2	“Сэлэнгийн брэнд” аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэн, дотоод, гадаадын зах зээлд нийлүүлнэ.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж-аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний нээлтийн хүрээнд “Сэлэнгэ Алтан намар 2022” нэгдсэн арга хэмжээ 10 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд Сэлэнгэ аймагт зохион байгуулагдлаа. Уг арга хэмжээнд сумын жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй эрхлэгч 6 иргэн 5 төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 3 сая гаран төгрөгний орлого олж, сумын 1 иргэн сүү цагаан идээний бэлгийн багц бүтээгдэхүүнээрээ шагнал хүртэж амжилттай оролцсон.	100%

3.4.3	Баялаг бүтээгч иргэдийн бие даасан, бүтээлч байдлыг дэмжих аяныг өрнүүлнэ.	Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, өрхийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, сурталчлах зорилгоор "ЦАГААННУУР УРГАЦ 2022" үзэсгэлэн худалдааг 2022 оны 11-р сарын 18-ны өдөр зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд мах махан бүтээгдэхүүн, сүү сүүн бүтээгдэхүүн, жимс жимсгэнэ, оёдол, гар урлал, хүнсний ногоо, даршилсан ногоо, мод модон эдлэл, сур суран эдлэл зэрэг 11 төрлөөр 24 өрхийн үйлдвэрлэгч 100 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээ танилцуулж оролцлоо. Цагааннуур ургац-2022 Үзэсгэлэн худалдаанд амжилттай оролцсон иргэд нийт 8,352,000 мянган төгрөгийн борлуулалтыг хийсэн байна. Үүнээс шилдэг 5 бүтээгдэхүүнийг шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнасан.	100%
3.4.4	Худалдаа үйлчилгээний салбарын орчин нөхцлийг сайжруулан үйлчилгээний соёл, хүний нөөцийг чадавхжуулна.	Худалдаа үйлчилгээ, цайны газрууд Хөдөлмөр хамгааллын хувцасаар жигдэрч үйлчилгээ үйл ажиллагаагаа явуулж байна. Ахуй үйлчилгээнээс халуун усны газар дотор орчин нөхцөлийг сайжруулан их засварын ажил хийгдэж дотор орчин нөхцөлөө сайжруулсан. Мөн худалдаа үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулан үйлчилгээний соёл, хүний нөөцийг чадавхжуулах мэдээ мэдээлэл зөвлөмж зэргийг худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн пэйж хуудасаар сурталчилан ажилласан. Хоол үйлдвэрлэл, хүнсний үйлдвэр, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдэд хууль тогтоомжийг сурталчлах, мөрдүүлэх, арга зүйн мэдлэгийг дээшлүүлж, зөвлөмж, зөвлөгөө өгөх зорилгоор “Хүнсний аюулгүй байдлыг хангуулах, зохистой дадлыг хэвшүүлэх, дотоод хяналтыг төлөвшүүлэх нь”, “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд эрүүл ахуйн зохистой дадлын зөвлөмжийг танилцуулах нь”, “Барилгын хэрэгцээ ба ашиглалт”, “Хийн баллон ашиглалт, цахилгааны аюулгүй байдал”, “Хүнсний тухай хууль”, “Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ, ерөнхий шаардлага MNS 5021-1:2019” сэдэвт сургалтыг Мэргэжлийн хяналтын газар, Стандарт хэмжилзүйн хэлтэс, Хөгжлийн шийдэл ТББайгууллагуудтай хамтран 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгууллаа.	100%

		Сургалтад 15 сумдын Хүнс, нийтийн хоол хариуцсан мэргэжилтэн, хоол үйлдвэрлэл, хүнс үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдийн төлөөлөл 181 иргэд оролцлоо. Найрамдал зах, Элгэмсэг мини маркет болон хүнсний дэлгүүр зэрэг тус тус гадна хаягаа шинэчилэн цагийн хувааарийг үүдэндээ байрлуусан байна.	
3.4.5	Нийтийн хоолны үйлдвэр, үйлчилгээний ажиллагсдыг сургах, мэргэшүүлэх, чадавхжуулах арга хэмжээ авч, сургууль, цэцэрлэгийг мэргэжлийн хоол зүйчтэй болгоно.	Хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдэд хууль тогтоомжийг сурталчлах, мөрдүүлэх, арга зүйн мэдлэгийг дээшлүүлж, зөвлөмж, зөвлөгөө өгч ажилласан. Сургууль, цэцэрлэг нь мэргэжлийн хоол зүйчтэй болоогүй.	70%
3.4.6	“Ахуйн үйлчилгээг хөгжүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Сумын хэмжэээнд ахуйн үйлчилгээний чиглэлээр нийт 19 иргэн, ААН үйл ажиллагаа эрхэлж байна. 2022 онд засварын иж бүрэн тоног төхөөрөмжтэй авто засварын газар ашиглалтад орсон бөгөөд ОНХС-ын хөрнөг оруулалтаар нийтийн боловсон 00 барих ажил 50 хувьтай явагдаж байна. Ахуй үйлчилгээний чиглэлээр явуулж буй иргэдийн ажлын байран 2 удаа хяналт шалгалтыг зохион байгуулж заавар, зөвлөмж зөвлөгөө өгч ажилласан.	70%
3.4.7	Барилгын материалын хийц, эдлэл үйлдвэрлэх санал, санаачилгыг дэмжин хэрэгжүүлнэ.	1 иргэнд “Төмөр хийц” төслөөр 5 сая төгрөгийг 24 сарын хугацаатай олгосон.	70%
<b>3.5. Хөрөнгө оруулалт, дэд бүтэц:</b>			
Хүн амын орон сууц, эрчим хүч, ус хангамж, ариутгах татуургын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж, иргэдийн эрүүл орчинд ая тухтай амьдрах нөхцөлийг сайжруулна.			
3.5.1	Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан түүхэн болон дурсгалт газруудыг сэргээн засварлаж, тохижуулна.	Хэрэгжээгүй	0%
3.5.2	Сумдад үерийн далан засварлах, гүүр барих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	2023 онд сумын ОНХС-аар 2-р багт үерийн далан байгуулахаар иргэдээс санал авч дэмжигдэн төсөст суулгасан.	100%
3.5.3	Агаарын хөлөг хөөрч, буух зурвас байгуулж, нислэг үйлдэх хэвийн үйл ажиллагааг хангана.	Хэрэгжээгүй	0%
<b>3.6. Санхүү, төсвийн зохицуулалт</b>			
Төсвийн ил тод байдал, сахилга батыг хангаж, төсвийн төлөвлөлтийн оновчтой хуваарилалт, зарцуулалтыг удирдан, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулж, иргэд олон нийтийн санхүү, төсвийн мэдлэгийг дээшлүүлнэ.			
3.6.1	Эдийн засгийн нөөц бололцоонд тулгуурласан	Төсвийн хэмнэлтийн хууль болон бусад хууль тогтоомжийг	100%

	төсвийн төлөвлөлтийг оновчтой зохион байгуулж, гүйцэтгэлийн хяналтын системийг сайжруулж, үр дүнгийн шинжилгээнд суурилан төсвийн ил тод байдлыг хангана.	хэрэгжүүлэн төсвийн төлөвлөлтийг хэмнэлттэй оновчтой зохион байгуулж, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ болон төсвийн хуваарилалт, төсвийн төсөл, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө тусламжаар хийгдсэн арга хэмжээ болон бусад мэдээллийг төсөвт байгууллага бүрээр тухай бүр сумын албан ёсны цахим хуудас <a href="http://tsagaannuur.se.gov.mn/">http://tsagaannuur.se.gov.mn/</a> болон мэдээллийн самбарт байршуулж, иргэд олон нийтийг шинэчлэгдсэн мэдээлэлтэй нээлттэй, чөлөөтэй танилцах боломжоор ханган ажиллаж байна.	
3.6.2	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын үйл ажиллагаанд эдийн засгийн үр ашгийн шинжилгээ хийж, үйл ажиллагааг сайжруулна.	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь үйл ажиллагаа 2021 оноос хойш хэвийн явагдаж байна.	100%
3.6.3	Татвар төлөгчдийн бүртгэлийг сайжруулж, тайлагналт, үйл ажиллагааг цахимжуулж, хуулийн хүрээнд татвар ногдуулах боломжийг эрэлхийлж татварын суурийг нэмэгдүүлнэ.	2022 онд Улс төлөвлөгөө-264,045.2 мянган төгр төвлөрөхөөс 592,528.2 мянган төгрөг буюу 224,4% Аймгийг төлөвлөгөө-169,493.3 мянган төгрөг төвлөрөхөөс 189,549 мянган төгрөг буюу 111.8% Сумын төлөвлөгөө-852,424 мянган төгрөг төвлөрөхөөс 836,527.9 мянган төгрөг буюу 98.1% нийт 1,285,963.1 мянган төгрөг төвлөрөхөөс 1,618,605 мянган төгрөг буюу 125.9% биелэсэн байна. Улс төлөвлөгөө 264,045.2 мянган төгрөг төвлөрөхөөс 592,528.2 мянган төгрөг буюу 224,4% Аймгийн төлөвлөгөө-169,493.3 мянган төгрөг төвлөрөхөөс 189,549.7 мянган төгрөг буюу 111.8% Сумын төлөвлөгөө-852,424.6 мянган төгрөг төвлөрөхөөс 836,527 мянган төгрөг буюу 98.1% нийт 1,285,963.1 мянган төгрөг төвлөрөхөөс 1,618,605.8 мянган төгрөг буюу 125.9% биелэсэн байна.	100%
3.6.4	Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулна.	Нийт 8 төсөвт байгууллагын хүний нөөц удирдлага мэдээллийн санд бүртгэлтэй 206 төрийн албан хаагчдын мэдээллийг шалгаж, төрийн албаны цалингийн нэгдсэн системд холбож, төрийн албаны цалингийн нэгдсэн системээс боловсруулагдаж гарсан төлбөрийн хүсэлтийг үндэслэж цалингийн олгож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавин, цалин хөлсний төлөвлөлтийг оновчтой болгон ажиллаж байна.	100%
3.6.5	Статистикийн мэдээ, тооллого, судалгааг үнэн, бодитой хийж, үр дүнгийн шинжилгээнд суурилсан	Мэдээ тайлан гаргах албан тушаалтныг Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр А/09 тоот захирамжаар	100%

	мэдээллийг хэрэглэгчдэд боломжит хэлбэрээр тархааж, бодлогын баримт бичиг боловсруулах үйл ажиллагаанд ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.	баталж, баталсан цаглабарын дагуу холбогдох мэргэжилтнүүдээр албан ёсны ХАА-1, 2, 3, 5, 6, 8, 9, 10, ААНБ-1, 2, АУ-1, ББО, ББӨ, ХУ-1 ЗГ-1, МЭ-1,БР-1, ХО-1, ОС-3,4 МТ-1, ХААТ-1 гэх мэт 30 төрлийн статистик мэдээг нийт 95 удаагийн давтамжтайгаар холбогдох мэргэжилтнээр үнэн зөв бодитой гаргуулан графикийн дагуу цаг хугацаанд нь аймгийн статистикийн хэлтэст цаасаар болон онлайнаар хүргүүлэн үр дүнг мэдээллийн самбар болон гарын авлагаар дамжуулан хэрэглэгчдэд тархааж байна.	
3.6.6	“Иргэн та эдийн засагч” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	“Иргэн та эдийн засагч” арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан засаг даргаар батлуулан холбогдох мэргэжилтнүүдэд танилцуулан төлөвлөгөөний дагуу ажлууд хийгдсэн. Үүнд: Ерөнхий боловсролын сургуулийн 28 сурагчид статистикийн боловсрол болон санхүүгийн эдийн засгийн мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан. Цахим хуудсаар дамжуулан нийгмийн даатгалын тухай ойлголт, татварын тухай ойлголтууд болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон бусад мэдээллүүдээр иргэд олон нийтийг шинэчлэгдсэн мэдээлэлтэй нээлттэй, чөлөөтэй танилцах боломжоор ханган ажилласан.	100%
<b>Дөрөв. Засаглалын бодлого</b> <b>4.1.Нутгийн захиргаа</b> <b>Төрийн үйлчилгээнд ухаалаг-тогтвортой засаглалыг бэхжүүлж, чадахуйн зарчимд суурилсан хариуцлагатай, шуурхай, нээлттэй, ил тод төрийн үйлчилгээг хүргэнэ.</b>			
4.1.1	Мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, чадахуйн зарчимд тулгуурласан ухаалаг, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлнэ.	Төрийн албан хаагчийг ажлын байранд нь чадавхжуулах, харилцаа, хандлага, ажлын үр дүн, гүйцэтгэл, ур чадварыг нэмэгдүүлэх онол, практик, олон улсын туршлагын шинэ мэдлэг, мэдээллийг түгээх зорилгоор Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан сургалтад цахимаар хамрагдсан.	100%
4.1.2	Төрийн албан хаагчийн ажиллах орчин, нийгмийн баталгааг хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж, төрийн бүх шатны байгууллагад суралцагч байгууллагын соёлыг бэхжүүлнэ.	Төрийн албан хаагчийн ажиллах орчин, нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд Багийн Засаг дарга нарын зөөврийн компьютерийг 4,5 сая төгрөгийн өртөгтэйгээр, ажлын ширээг 1,5 сая төгрөгийн өртөгтэйгээр бүрэн шинэчилсэн.	100%
4.1.3	Төрийн албан хэрэг хөтлөлтийг кирил болон үндэсний бичгээр хослуулан явуулах бэлтгэл ажлыг	“Монгол бичиг үндэсний хөтөлбөр-III” хүрээнд төсвийн байгууллагын ажилчдаас үндэсний бичгийн мэдлэгийн	100%

	шат дараатай хэрэгжүүлнэ.	талаар тандалт судалгааг онлайнгаар авч нэгтгэн түүний дагуу төсвийн ажилчдад ээлж дараалан үндэсний бичгийн анхан шатны сургалтыг зохион явуулж эхэлсэн. Үүнд 1-р цэцэрлэгийн 28 багш ажилчдад анхан шатны 1 сарын сургалтыг зохион байгуулж хамрагдсан багш ажилчдадаа сертификат олголоо.	
4.1.4	Төрийн үйлчилгээний цахим шилжилтийг хэрэгжүүлж, цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлнэ.	E-mongolia цахим үйлчилгээний талаар сумын веб сайт болон цахим хаягаар дамжуулан сурталчлан ажиллаж байна. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар оператороор дамжуулан 154, гар утасны апплейшнаар зөвлөгөө мэдээлэл, туслалцааг 184 иргэнд үзүүлсэн.	100%
4.1.5	Иргэдийн санал, өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх зарчмыг баримтлан “Таныг сонсьё” арга хэмжээг төрийн бүх шатны байгууллагуудад хэрэгжүүлж, захиргааны шийдвэр гаргах, хянах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	3 дугаар улирлын байдлаар сумын төр, төсвийн байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс 36 өргөдөл гомдол ирүүлсэн бөгөөд 100 хувь хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн. 2021 оны ажлын үр дүнг тайлагнах, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх зорилгоор 02 дугаар сард сумын ИТХ-ын төлөөлөгчид, ЗДТГ, ЭМТ-ийн ажилтнууд хамтран 8 хэсэг болж 1, 3 дугаар багийн 380 малчин өрхөөр явж өвөлжилт хаваржилтын байдалтай танилцан, сумын ЗДТГ-аас 2021 онд зохион байгуулсан ажлын тайлан болон цаг үеийн ажлын мэдээлэл хүргэж ажиллалаа. Сумын Засаг дарга 1 дугаар улиралд 1, 2, 3 дугаар БИНХ-аар, 2 дугаар улиралд төр төсвийн байгууллагуудын албан хаагчидтай, 3 дугаар улиралд 2,3 дугаар багийн өдөрлөгөөр малчид иргэдтэй уулзалт зохион байгуулж ажиллалаа.	100%
4.1.6	Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг үр дүнтэй хэрэгжүүлэх мэдээллийн дэд бүтцийг хэрэглээнд нэвтрүүлнэ.	Засаг даргын Тамгын газрын албан хэрэг хөтлөлт, албан бичиг солилцоонд Able, Төрийн байгууллагын цахим шуудан email.gov.mn цахим систем ашиглаж байна.	100%
4.1.7	Орон нутгийн төр, төсвийн байгууллагуудын үйл ажиллагаа болон хөгжлийн бодлогын баримт бичигт төлөвлөлт, явц, гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж, үр дүнг тооцох тогтолцоог бэхжүүлнэ.	Төр төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны тайлан болон бодлогын баримт бичгийн биелэлтийг улирал, жилээр авч нэгтгэн, аймгийн ЗДТГ, сумын ИТХ-д тайлагнан ажиллаж байна. 2022 онд Сэлэнгэ аймаг дахь төрийн аудитаас 2021 оны санхүүгийн гүйцэтгэлийн аудит, Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, Аудитын албаны төлөвлөгөөт хяналт шалгалт тус бүр 1 удаа, 2021, 2022 оны эхний хагас жилийн сумын дотоод хяналт шалгалтыг 3 удаа хийгдсэн.	100%

4.1.8	Баг, тосгодоос иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулна.	Багийн өдөрлөгийн байрыг сэргээн засварласан.	100%
4.1.9	Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах, сэрэмжлүүлэх үйл ажиллагаанд бүх нийтийн оролцоо, мэргэжлийн байгууллагын бэлэн байдлыг ханган, гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлж, шаардлагатай сумдад Онцгой байдлын тасаг, нэгжийг байгуулна.	Сумын Засаг даргын захирамжаар СОК, ГХШШ-ын бүтэц бүрэлдэхүүнийг шинэчлэн батлаж бэлтгэл, бэлэн байдлыг ханган УОК-с зарласан Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг, Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед бүрэн бүрэлдэхүүнээр ажилласан. Аймгийн хэмжээнд Гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага, сургууль 06 сарын 3-5-ны өдрүүдэд “Танхимын сургалт”, “Бэлэн байдлын үзлэг”, “Штабын дадлага”, “Дадлага, сургууль” гэсэн үндсэн дөрвөн хэсэгтэйгээр явагдлаа. Штабын дадлага сургууль нь сумын нутаг дэвсгэрт хүчтэй газар хөдлөлт, малын гоц халдварт өвчин болсон үеийн удирдлагын хариу арга хэмжээ, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн анги, албадын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл, бэлэн байдлын төлөвлөгөөг тодотгох, өгөгдсөн цагийн байдлын дагуу бүлгээр ажиллах дадлагаар явагдлаа. “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-ийн иргэдийг аюулгүй нүүн шилжих дадлага сурууль 2022 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн өглөө 10:00 цагт түр цугларах талбайд, сургуулилтад 689 иргэн хамрагдлаа. 2022 оны 06 дугаар сарын 05-ны Сумын улаан загалмайн анхан шатны хороо, сумын ЗДТГ хамтран “Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдөр”-т зориулан гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог дэмжин идэвхжүүлэх, хамтран ажиллах “Бэлэн бай” сургалт зохион байгуулж 15 иргэн хамрагдсан. Суманд гамшгаас хамгаалах Эрэн хайх аврах салбар анги байгуулах саналыг Аймгийн Онцгой байдлын газар, Аймгийн Засаг даргаар дамжуулан МУ-ын Засгийн газарт санал хүргүүлсэн. Зураг төслийн ажил хийгдэж байна	100%
<b>4.2. Хууль эрх зүй</b> Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх замаар иргэн бүр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлдэг төлөвшлийг бий болгож, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журмыг хангах ажлыг дээшлүүлж, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангана.			
4.2.1	“Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутагт хангах бодлого”-ыг боловсруулан хэрэгжүүлнэ.	Үндэсний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар гарын авлага, мэдээлэл бэлтгэн төрийн албан хаагч, иргэдэд сурталчлан ажилласан.	100%



		Үндэсний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу Гамшгаас хамгаалах тухай хууль, Ковид-19 болон бусад төрлийн хүн, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 2 удаа зохион байгуулж 35 иргэн хамрагдсан. Цас, зуд, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлгийг цахимаар болон алслагдсан багийн иргэдэд багийн Засаг дарга нар гар утас ашиглан шуурхай хүргэж байна. Эрчим хүч, дулаан хангамжийн аюулгүй байдалд улирал бүр үзлэг хийж, шаардлагатай засвар үйлчилгээг тухай бүр мэргэжлийн байгууллагатай хамтран хийж гүйцэтгэсэн.	
4.2.2	Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай хүргэн иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.	Хувь хүний орлогын албан татвар, Авлигын эсрэг, Төрийн албан хаагчийн ёс зүй, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлт, Хүнсний эрхийн бичиг олгох журмын тухай зэрэг 7 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 460 иргэнийг хамруулсан байна. “Эрх зүйн хөтөч”-ийн булангаар дамжуулан 1 иргэн цахимаар, 26 иргэн утсаар хууль зүйн зөвлөгөө мэдээлэл авсан. Хууль, эрх зүйн сэдэвт гарын авлага 200ш тараагдсан байна.	100%
4.2.3	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.	Цагааннуур сумын цагдаагийн хэсэг нэртэй цахим хуудсыг ажиллуулж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх шторк, постыг тогтмол байршуулж байна. Мөн иргэдийн эрх зүйн боловсролд зориулан Зөрчлийн тухай хууль болон Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн талаар мэдээлэл байрлуулж ажилласан.	100%
4.2.4	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нийтэд түгээн авлига, албан тугаалын гэмт хэргээс ангид байх хандлагыг төлөвшүүлнэ.	Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах, Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 3 удаагийн сурталтад давхардсан тоогоор 86 төрийн албан хаагч хамрагдсан. Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын хор аюулыг ухуулан таниулах, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд “Зөв зөвд шударга зөв” нөлөөллийн аянд нэгдэж аяны талаарх мэдээллийг иргэдэд цахимаар хүргэсэн. Соён гэгээрүүлэх аяны хүрээнд 12 төрлийн сурталчилгааны хуудас, 9 төрлийн зөвлөмж, 14 видео	100%

		бичлэгийг сумын цахим хуудааст байршуулсан.	
4.2.5	Бүх нийтэд хүний эрхийн боловсрол олгож, иргэн бүрийн аюулгүй байдлаа хангах мэдлэг, мэдээллийг нийгэмд түгээн, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	“Иргэн таны хүний эрхийн боловсролд” цахим нийтлэлийг 5 удаа цувралаар олон нийтэд хүргэж ажилласан.	100%
4.2.6	“Нэг иргэн-нэг бүртгэл” арга хэмжээг үргэлжлүүлэн улсын бүртгэлийн мэдээллийг цахимаар авах боломж нөхцөлийг сумдад бүрдүүлнэ.	2022 оны 1 дүгээр сараас эхлэн сумын хэмжээнд хөтлөгдсөн иргэний бүртгэлийн маягт, эх нотлох баримтыг цахимжуулж эхэлсэн бөгөөд 473 маягт нийт 1040 цаасан эх нотлох баримтыг цахимжууллаа. Монгол Улсын иргэнд олгох тоон гарын үсгийг сурталчилан, нэвтрүүлж 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн тоон гарын үсгийг олгож эхлэлээ. Сумын 681 иргэнд тоон гарын үсгийг олгоод байна. Мөн цахим гадаад паспортад бичих тоон гарын үсгийг нэвтрүүлсэн байна. Иргэний бүртгэлийн онлайнд холбогдсоноор иргэний гэр бүлийн 9 төрлийн бүртгэлийг онлайнаар бүртгэж иргэний баримтын 14 төрлийн лавлагааг иргэдэд олгох боломжтой болсон.	100%
<b>4.3. Батлан хамгаалах</b>			
Орон нутгийн хамгаалалтын тогтолцоо бэхжиж, батлан хамгаалах чадавх дээшилсэн байна.			
4.3.1	Цэргийн насны залуучуудыг алба хаах хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх, эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.	2022 оны 1-р ээлжийн цэрэг татлагад 35 залуу хамрагдснаас 1 иргэн тэнцсэн, 2-р ээлжийн цэрэг татлагад 50 залуу хамрагдснаас 18 иргэн тэнцэж цэргийн албанд татагдсан. Цэргийн насны залуучуудыг алба хаах хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх, эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор Сэлэнгэ аймгийн Засаг даргын нэрэмжит сумын аварга шалгаруулах Цэрэг-Спортын "Дөл" тэмцээн 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр суманд явуулж улмаар бүсийн сумдаас шалгарсан багуудын дунд Сэлэнгэ бүсийн сумдуудын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан.	100%
4.3.2	Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийг иргэд, олон нийтэд сурталчлан, таниулах ажлыг зохион байгуулж, бүх нийтийн оролцоотойгоор орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангах, хамгаалах олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөнд тодотгол хийж, хуулийг олон нийтэд цахимаар танилцуулсан.	100%

**Тав. Ногоон хөгжил**

Байгалийн унаган төрхийг хадгалж, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглан, байгальд ээлтэй үзэл санааг түгээн дэлгэрүүлнэ.

5.1.1	<p>Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад тогтвортой ногоон хот, ногоон барилга, амьдралын хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг дэмжих, мэдлэг олгоно.</p>	<p>Сумын хэмжээнд “Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах тухай” А/116 тоот захирамжийн дагуу 2022 оны 10 дугаар сарын 7-ноос 08-ны өдрүүдэд зохион байгуулан ЗДТГ-ын 30 ажилтан албан хаагчид, Худалдаа үйлчилгээ эрхэлдэг 31 иргэд, 9 аж ахуй нэгж байгууллагын 40 иргэн, ерөнхий боловсролын сургуулийн 6-12-р ангийн 518 сурагчид цэвэрлэгээнд оролцож ойр орчмынхоо 50м болон сумын төв доторх нийт 20 тонн хогийг цэвэрлэж хогийн нэгдсэн цэгт буулгасан. Мөн аймгийн БОАЖГ-аас зохион байгуулсан хог хаягдлын талаар сэтгэлгээг өөрчлөн, дахин боловсруулахын ач холбогдлыг таниулах, мэдлэгийг дээшлүүлэх, хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах талаар сургалтад сумын 2-р багийн нэг иргэн хамрагдаж сумандаа дахивар нөөц худалдан авах цэгийг ажиллуулах хүсэлтээр ЕБСургуулийн гадна талбайд хувцар савыг цуглуулах хогийн савыг байрлуулж хүлээлгэн өгсөн. “Бөмбөрцгийн сүмбэ хүүхдийн байгууллага” НҮББ, QPAY-аас монгол улсын 21 аймагт зохион байгуулах “АЮУЛЫГ АВДАРЛАЯ-1” уралдаанд янжуурын ишийг өөрийн амьдардаг гэр, байр, хашаа гудамж, тоглоомын талбай орчмоос түүж савлан очноо цэвэрлэхэд идэвх санаачлагатай оролцсон ЕБС-ийн Ц.Батчимэг багштай 86 ангийн хамт олон аймагт 3-р байр эзэлсэн.</p>	100%
5.1.2	<p>“Ногоон сум” хөдөлгөөнийг өрнүүлнэ.</p>	<p>Аймгийн Засаг даргын “Бүх нийтээр мод тарих арга хэмжээ зохион байгуулах” ажлын хүрээнд 5,10-р сард “ТЭРБУМ МОД-ЦАГААННУУР СУМ 2022” зөвлөгөөнийг сум дундын ойн ангитай хамтран зохион байгуулж Шаамар сумын мод үржүүлгийн газруудтай хамтран тарьц суулгацны үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа. Нийтийн эдэлбэр газарт шинээр 6 ширхэг бичил цэцэрлэг 3 га-д байгуулсан. Үүнд нарс 258 ширхэг, гоёлын мод 360 ширхэг, иргэд гоёлын мод-21 ширхэг, жимсний мод-69 ширхгийг, ААНБайгууллага гоёлын мод-82 ширхэг, жимсний мод-184 ширхгийг тус тус тарьсан байна. Сумын хэмжээнд нийт шилмүүст мод-258 ширхэг, гоёлын мод-381 ширхэг,</p>	100%

		<p>жимсний мод-253 буюу нийт 892 ширхгийг тарьсан байна. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд байгуулагуудын гаднах ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд аж ахуйн нэгжүүдийн дунд зохиогдсон арга хэмжээний хүрээнд экологийн боловсрол олгон туршилтын 400м2 талбайг бий болгон 8 төрлийн 160 гаруй мод тарин 27ш бичил цэцэрлэгийн мандалд 10 төрлийн 4500ш цэцэгийг тарьж “ШИЛДЭГ НОГООН БАЙГУУЛАМЖТАЙ БАЙГУУЛЛАГА”-аар 1-р цэцэрлэг шалгарсан.</p>	
5.1.3	<p>Гэр хорооллын болон аялал жуулчлалын бүсэд “Био жорлон” арга хэмжээг зохион байгуулж, хөрсний бохирдлыг бууруулна.</p>	<p>Нүхэн жорлон ашигласны улмаас хөрс болон усны бохирдол үүсэх нөхцөл бүрдэх тул сумын төвд үйл ажиллагаа явуулдаг 12 аж ахуй нэгж, 28 иргэнд энгийн нүхэн жорлонгоо эко нойл болгох талаар зөвлөмж хүргэж ажилласан. Тус ажлын хүрээнд Шунхлай ШТС, Ник петролиум ШТС-иуд энгийн нүхэн жорлонгоо нурааж, эко нойл болгон барьсан байна. Мөн сумын 3-р багийн төвийн хэсэгт ОНХСанхүүжилтаар Баяжих ундрах ХХК нь 80.000.000 төгрөгийн тендерт оролцон гэрээ байгуулан сити нойлыг бий болгохоор ажиллаж байна. Байгаль орчны тухай хууль, хог хаягдлын тухай хууль, эрүүл ахуйн тухай хуулиудыг цахимаар болон 200 ширхэг гарын авлага бэлтгэн тараасан.</p> <p>Сумын ОНХС-ын хөрөнгө оруулалтаар нийт 48.2 сая төгрөгийн үнэ бүхий бохир соруулах машиныг Арби Элеваторс ХХК-аас 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдөр ажлын хэсэг хүлээн авч сумын ААНБайгууллага, 5 айл өрхийн бохирыг соруулж байна. Сумын хэмжээнд 10 ААНБайгууллага, 12 айл өрхүүд нэгдсэн бохирын шугамд холбогдсон.</p>	70%
5.1.4	<p>Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлж, гудамж талбайн гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлнэ.</p>	<p>Нийтийн эдэлбэр газарт шинээр 6 ширхэг бичил цэцэрлэг 3 га-д байгуулсан. Үүнд нарс 258 ширхэг, гоёлын мод 360 ширхэг, иргэд гоёлын мод-21 ширхэг, жимсний мод-69 ширхгийг, ААНБайгууллага гоёлын мод-82 ширхэг, жимсний мод-184 ширхгийг тус тус тарьсан байна. Сумын хэмжээнд нийт шилмүүст мод-258 ширхэг, гоёлын мод-463 ширхэг, жимсний мод-253 буюу нийт 974 ширхгийг тарьсан байна. Аймгийн замын сангийн хөрөнгөөр 32,5 сая, сумын</p>	100%

		ОНХС-ийн хөрөнгөөр 13,9 сая нийт 46.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр “Авто мастер төв” ХХК шалгаран 100 хувь хийж гүйцэтгэсэн. Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 28,8 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр “Баяжих ундрага ХХК” төв доторх зам дагуу 10 байршилд 16 камерыг шинээр байрлуулан хүлээлгэж өгсөн.	
5.1.5	Агаар, орчны бохирдлын эх үүсвэр, хор уршиг, сөрөг нөлөөллийн талаар олон нийтэд мэдээлж, зөв дадалд сургана.	20 төрлийн мэдээ мэдээллийг сумын цахим хуудсаар дамжуулан иргэдэд нөлөөлөн ажиллаж байна.	100%

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН  
2022 ОНЫ ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮНГИЙН НЭГТГЭЛ**

2022.12.14

Цагааннуур сум

Зорилт арга хэмжээ	Заалт	2022 он /хувь					Дүн
		0	30	50	70	100	
<b>НЭГ.“КОВИД-19” БОЛОН БУСАД ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО</b>							
Зорилт 1	11	1				10	90.9
<b>Дүн</b>	<b>11</b>	<b>1</b>				<b>10</b>	<b>90.9</b>
<b>ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>							
Эрүүл мэнд	8				2	6	92.5
Боловсрол	6					6	100
Биеийн тамир, спорт	7				1	6	95.7
Соёл, урлаг	7			1	1	5	88.5
Хүүхэд, залуучууд, гэр бүлийн бодлого	7				1	6	95.7
Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, даатгал	7					7	100
<b>Дүн</b>	<b>42</b>			<b>1</b>	<b>5</b>	<b>36</b>	<b>88.5</b>
<b>ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b>							
Хөдөө аж ахуйн бодлого	8				3	5	88.7
Байгаль орчин	6	1			2	3	73.3
Аялал жуулчлал	1				1		70
Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ	7				3	4	87.1
Хөрөнгө оруулалт, дэд бүтэц	3	2				1	33.3
Санхүү, төсвийн зохицуулалт	6					6	100
<b>Дүн</b>	<b>31</b>	<b>3</b>			<b>9</b>	<b>19</b>	<b>81.6</b>
<b>ДӨРӨВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО</b>							
Нутгийн захиргаа	9					9	100
Хууль эрх зүй	6					6	100
Батлан хамгаалах бодлого	2					2	100
Ногоон хөгжил	5				1	4	94
<b>Дүн</b>	<b>22</b>				<b>1</b>	<b>21</b>	<b>98.6</b>
<b>Нийт дүн</b>	<b>106</b>	<b>4</b>		<b>1</b>	<b>15</b>	<b>86</b>	<b>91.5</b>

НЭГТГЭЛ ХИЙСЭН: ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.АЛТАНЗОРИГ

ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГА

Ц.БАЯНБААТАР